

Батлав. Тэргүүн

Б.Цэдмаа



ЭХ БАРИХ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭМЧИД МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1. Эх барих, эмэгтэйчүүдийн эмчид ахлах зэрэг олгох нийтлэг шалгуур:

- 1.1 Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй эсвэл зөвшөөрөл шаардлагагүй мэргэжилтэн нь мэргэжил эзэмшсэн диплом, мэргэшлийн үнэмлэхтэй байх
- 1.2 Тухайн мэргэжлээрээ 8-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх
- 1.3 Тухайн мэргэжлээрээ төрөлжсөн мэргэжил эзэмшсэн байх
- 1.4 Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх /байгууллагын тодохойлолтод тусгах/

Тусгай шалгуур

2. Эх барих, эмэгтэйчүүдийн эмчид ахлах зэрэг олгох тусгай шалгуур:

- 2.1 Багц цагийн биелэлтийг баталгаажуулах гэрчилгээний хуулбар /сүүлийн 3 жилээр, жилд 6 багц цаг/
- 2.2 Мэргэжлийн зөвлөмж эсвэл байгууллагын түвшинд эмчилгээ, үйлчилгээний удирдамж, стандарт 2-оос доошгүй гаргасан байх
- 2.3 Эзэмшсэн мэргэжлээрээ сүүлийн 3 жилд 1-2 судалгааны ажил хийж онол практикийн бага хурлуудад илтгэл хэлэлцүүлсэн байх /илтгэлийн хураангуй хуулбар/
- 2.4 Кесар, умай, өндгөвч, дайврын хоргүй хавдар, умайн гаднах жирэмслэлт болон умайгаас зангилаа авах эзэмшсэн байх мэс засал хагалгаануудын техникийг эзэмшсэн байх /сүүлийн 3 жилд хийсэн ажлын тайлан/ эсвэл эрхтэн тогтолцооны эмгэг ба хүндрэлтэй жирэмсэн, эмэгтэйчүүдийн хавдар урогенокологийн эмгэгийн тохиолдолд суурилсан оношлогоо, эмчилгээний аргаар шалгалт өгч болно.

Ахлах зэргийн эмч ажиллаж байгаа тасагтаа зөвлөгөө өгөх чадвар эзэмшсэн байх

3. Эх барих, эмэгтэйчүүдийн эмчид тэргүүлэх зэрэг олгох нийтлэг шалгуур:

- 3.1 Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй эсвэл зөвшөөрөл шаардлагагүй мэргэжилтэн нь мэргэжил эзэмшсэн диплом, мэргэшлийн үнэмлэхтэй байх
- 3.2 Тухайн мэргэжлээрээ 13 түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх, одоо тухайн мэргэжлээрээ ажиллаж буй
- 3.3 Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх /байгууллагын тодохойлолтод тусгах/

Тусгай шалгуур

- 3.4 Багц цагийн биелэлтийг баталгаажуулах гэрчилгээний хуулбар /сүүлийн 3 жилээр, жилд 6 багц цаг/
- 3.5 Сүүлийн 5 жилийн хугацаанд боловсруулсан аймаг, дүүргийн түвшинд оношлогоо, эмчилгээний стандарт, шинэ оновчтой санал санаачлага гаргасан, бичсэн ном, удирдамжийн аль нэг байх /эдгээрийн хуулбар/
- 3.6 Эзэмшсэн мэргэжлээрээ сүүлийн 5 жилд 3-аас доошгүй судалгааны ажил хийж онол практикийн бага хурлуудад илтгэл хэлэлцүүлсэн байх /илтгэлийн хураангуй хуулбар/
- 3.7 Эх барих, эмэгтэйчүүдийн практикт хийгдэх мэс заслуудын техникийг бүрэн төгс эзэмшсэн байх /сүүлийн 3 жилд хийсэн ажлын баталгаажсан тайлан/. Мэс засал, үүнд: Умайг дайвартай, дайваргүй үтрээн дээгүүр бүхлээр авах мэс засал хийх, өндгөвчний уйланхай, хавдар авах, хүндрэлтэй, 3-4 дэх давтан кесар мэс засал, ихэс түрүүлэлт, сорвины жирэмсэн үеийн хагалгаа, дурангийн мэс заслаар шалгалт өгнө. Эсвэл эмэгтэйчүүд болон охидын дотоод шүүрлийн эмгэг, эмэгтэйчүүдийн өвчний (охидын цус алдалт, цэвэрших хам шинж, эмэгтэйчүүдийн цус алдалт) эрхтэн тогтолцооны эмгэг ба илүү тээлт, хүндрэлтэй жирэмсэн, эмэгтэйчүүдийн хавдар урогенокологийн эмгэгийн тохиолдолд суурилсан оношлогоо эмчилгээний аргаар шалгалт өгнө.
- 3.8 Шавилан сургалтаар 3-5 мэргэжлийн эмчийг дагалдуулан сургасан байх /ажлын тайланд тусгахдаа дагалдуулсан эмчийн нэр, дагалдуулсан хугацааг бичих/
- 3.9 Ард иргэдэд зориулсан болон мэргэжлийн ном товхимол, орчуулга хийсэн, хянан тохиолдуулсан, бичсэн, гарын авлага зөвлөмж гаргасан байх
- 3.10 Тусгай эмнэлэг, амаржих газар, АНЭ-ийн эмч нарын сургалтанд багшаар оролцсон байх /байгууллагын даргын тодорхойлолтоор/

Тэргүүлэх зэргийн эмч нь ажиллаж буй нэгж байгууллагадаа зөвлөгөө өгөх чадвар эзэмшсэн байна.

4. Эх барих, эмэгтэйчүүдийн эмчид зөвлөх зэрэг олгох нийтлэг шалгуур:

- 4.1 Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, зөвшөөрөл шаардлагагүй мэргэжилтэнд мэргэжлийн диплом, мэргэшлийн үнэмлэхтэй байх
- 4.2 Тухайн мэргэжлээрээ төрөлжсөн мэргэжил эзэмшсэн байх
- 4.3 Мэргэжлээрээ 20 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх, одоо тухайн мэргэжлээрээ ажиллаж буй
- 4.4 Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх /байгууллагын тодохойлолтод тусгах/
Тусгай шалгуур
- 4.5 Сүүлийн 3 жил багц цагийн биелэлтийг баталгаажуулах гэрчилгээний хуулбар /жилд 6 багц цаг/
- 4.6 Үндэсний түвшинд мөрдөх оношлогоо эмчилгээний стандарт, бичсэн ном, удирдамж, шинэ оновчтой санаа аль нэгийг боловсруулан гаргасан байх /эдгээрийн хуулбар/
- 4.7 Эзэмшсэн мэргэжлээрээ сүүлийн 5 жилд 4-өөс доошгүй судалгааны ажил хийж онол практикийн бага хурлуудад илтгэл хэлэлцүүлсэн байх /илтгэлийн хураангуй хуулбар/

- 4.8 Эх барих, эмэгтэйчүүдийн практикт хийгддэг бүх төрлийн мэс заслуудын техникийг бүрэн төгс эзэмшсэн байх /сүүлийн 3 жилд хийсэн ажлын баталгаажсан тайлан/. Мэс засал, үүнд: Умайг үтрээн дээгүүр болон бүхлээр дайвартай авах мэс засал, дурангийн мэс засал умай авах, умайн артери боох, үтрээгээр умай авах, өндгөвчний хавдар, том уйланхай авах, мэс заслын тоо, эс вэл зөвлөх зэргийн эмчид гадаад оронд эмчлүүлэхээр илгээгддэг өвчний (анхдагч, хоёрдогч үргүйдэл, мэс заслын шалтгаант цэвэршилт) тохиолдолд суурилсан шалгалт өгнө.
- 4.9 Тухайн мэргэжлээрээ сургалт, семинар, конференц, зөвлөгөөнийг зохион байгуулж удирддаг байх /ажлын тайландаа хурал, коференцын нэр, хугацааг тусгах/
- 4.10 Эх барих, эмэгтэйчүүдийн эмчийн мэргэшүүлэх, дадлагажуулах сургалтанд багшилж байсан туршлагатай /ажлын тайландаа тодорхой тусгах/
- 4.11 Өөрийн мэргэжлийн үйл ажиллагаагаараа эмчилгээ оношлогооны шинэ санаачлага, оновчтой санал гаргаж патент авсан байх /сүүлийн 5 жилийн хугацаанд/
- 4.12 Шавилан сургалтаар 6 ба түүнээс дээш мэргэжлийн эмчийг дагалдуулан сургасан байх /сүүлийн 5 жилээр хийсэн ажлын тайландаа дагалдуулсан эмчийн нэр, дагалдуулсан хугацааг бичих/

Зөвлөх зэргийн эмч эрүүл мэндийн аль ч байгууллагад зөвлөгөө өгөх чадвар эзэмшсэн байна.

МОНГОЛЫН ЭХ БАРИХ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭМЧ НАРЫН НИЙГЭМЛЭГ

2018 оны 8 дугаар сарын 25